

БАТЛАВ.ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ж.БАТ-ЭРДЭНЭ

**УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫГ ХАМТРАН
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭ**

2018 оны 02 дүгээр
сарын 02 ны өдөр


№ 21

Улаанбаатар хот

Нэг талаас Зам, тээврийн хөгжлийн яам/ “цаашид яам” гэх/-ыг төлөөлж Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Т.Гомбосүрэн, нөгөө талаас Далайн захиргааг төлөөлж дарга С.Түвшинтөр нар харилцан тохиролцож дараах нөхцөлөөр гэрээ байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Усан замын тээврийн салбарт мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх, хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.
- 1.2. Улсын хэмжээнд усан замын тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх үйлчилгээ, тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагаанд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм журам, стандарт, Зам, тээврийн хөгжлийн яамны бодлого, дүрэм журмын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллана.
- 1.3. Хяналт шалгалтын ажилд Усан замын тээврийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм, журам, Мэргэжлийн хяналт шалгалтын стандарт, зөвлөмж, зааврыг үйл ажиллагаандаа удирдлага болгон холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллана.
- 1.4. Хяналт шалгалтын үйл ажиллагаанд “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн 4 дүгээр зүйлд заасан зарчмыг баримтлан хяналт шалгалтыг зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хийхээс гадна тухайн онд хийх хамтарсан хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг баталж, шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөт бус шалгалтыг хоёр тал зөвшилцөн хамтран хэрэгжүүлнэ.
- 1.5. Улсын байцаагчдыг сургалтад хамруулах, давтан сургах ажлыг хоёр тал хамтран зохион байгуулна.
- 1.6. Хяналт шалгалтын ажлыг холбогдох Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулна.
- 1.7. Энэхүү гэрээ нь хоёр тал тохиролцон гарын үсэг зурсан өдрөөс эхлэн тус гэрээг дүгнэн цаашид үргэлжлүүлэх эсэхийг шийдэх хүртэлх хугацаанд хүчинтэй.



Хоёр. Яамны эрх, үүрэг

2.1. Улсын байцаагчийн эрх олгуулах, сунгуулах, цуцлахтай холбоотой асуудлыг тус яам холбогдох журамд заасны дагуу Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

2.2. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2009 оны 214 дүгээр тушаалаар баталсан "Хуулиар эрх олгогдсон байгууллагад улсын байцаагч ажиллуулах журам"-ын 1.6-д заасныг үндэслэн өөрийн байгууллагын нэртэй улсын байцаагчийн акт, албан шаардлага, дүгнэлтийн хэвлэмэл хуудсыг хэвлүүлж, байцаагч нарт олгоно.

2.3. Усан замын тээврийн салбарт ажиллаж буй хяналтын улсын байцаагчдыг мэргэжил, арга зүйн болон хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдуулан батлан гаргасан эрх зүйн акт, мэдээллээр хангана.

2.4. Хяналт шалгалтын ажлын хагас, бүтэн жилийн нэгдсэн тайланг хүлээн авч, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж, зааварчлагаа өгөх, шаардлагатай тохиолдолд хариуцлага тооцуулах саналыг холбогдох газарт гаргах.

2.5. Яамнаас хийх төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтад шаардлагатай бол Далайн захиргааны усан замын тээврийн улсын байцаагчдыг татан оролцуулах.

Гурав. Далайн захиргааны эрх, үүрэг

3.1. Усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх үйлчилгээ, тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, аюултай ачаа тээвэрлэх үйл ажиллагаанд Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилтэнд улсын байцаагчаар дамжуулан байнгын хяналт тавьж, биелэлтийг хангуулж ажиллана.


3.2. Улсын байцаагчийн эрх олгуулах, сунгуулах, цуцлахтай холбоотой асуудлыг шийдвэрлүүлэхдээ, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2009 оны 214 дүгээр тушаалаар батлагдсан "Хуулиар эрх олгогдсон байгууллагад улсын байцаагч ажиллуулах журам"-д заасан баримтыг яаманд хүргүүлнэ. (шинээр улсын байцаагчийн эрх авах албан хаагчийн холбогдох баримтыг тус яамны ЗТХХ-ээр урьдчилан хянуулсан байна)

3.3. Улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг, шийтгэлийн хэрэглээнд хяналт тавьж ажиллана.

3.4. Усан замын тээврийн хяналтын улсын байцаагч нарыг хяналт, шалгалтад ажиллуулахдаа "Усан замын тээврийн тухай" хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан хөдөлмөр хамгааллын хувцас болон унаа, техник хэрэгслээр хангасан байна.

3.5. Улсын байцаагчийн тавьсан шийтгэлийн орлогыг сар бүр Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын "хяналтын орлого"-ын дансанд төвлөрүүлнэ.

3.7. Хяналт шалгалтын ажлын хагас, бүтэн жилийн нэгдсэн тайланг тухайн жилийн 5 болон 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор тус яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод, аудитын газарт ирүүлсэн байна.



Дөрөв. Бусад асуудал.

- 4.1. Талууд хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулахад хоёр тал аливаа хэлбэрээр саад учруулахгүй.
- 4.2. Хамтын ажиллагааны явцад хоёр байгууллагын эрх ашиг хөндөгдсөн асуудлыг тухай бүр удирдлагын хэмжээнд хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 4.3. Хамтарсан үзлэг, шалгалт, нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг оны эхэнд гарган хамтран батлах бөгөөд гэрээний салшгүй хэсэг байна.
- 4.4. Хамтарсан үзлэг, шалгалт, нэгдсэн арга хэмжээний дүнг гарган хэлэлцэх болон хамтын ажиллагааны бусад асуудлыг тухай бүр хамтран шийдвэрлэнэ.
- 4.5. Гэрээг жил бүрийн 12 дугаар сарын 28-ны өдрийн дотор дүгнэнэ.
- 4.6. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба гэрээний нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй байна.
- 4.7. Далайн захиргаа нь гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй тохиолдолд яам гэрээг дангаар цуцална.
- 4.8. Гэрээ байгуулагч байгууллага татан буугдсан, гэрээний харилцааг зохицуулсан эрх зүйн орчинд өөрчлөлт орж гэрээг дуусгавар болгох нөхцөл байдал бий болсон, эсхүл талууд харилцан тохиролцсоноор гэрээ дуусгавар болно.


ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА



Т.ГОМБОСҮРЭН

ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ДАРГА



С.ТУВШИНТӨР



БАТЛАВ.
 ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
 ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
 Ж.БАТ-ЭРДЭНЭ

**УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР 2018 ОНД
 ХАМТРАН АЖИЛЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

д/д	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцсан албан тушаалтан
А. Сургалт семинар			
1	Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд “Усан замын тээврийн аюулгүй ажиллагаа” сэдэвт хамтарсан семинар зохион байгуулах	II улиралд	ЗТХЯ, Далайн захиргаа, Орон нутгийн ОБГ, МХГ, УЗХороо
2	Усан замын тээврийн хяналтын улсын байцаагчийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор мэргэжил арга зүйгээр хангах, мэргэжил дээшлүүлэх сургалт, семинарт тогтмол хамруулж байх	I-IV улиралд	ЗТХЯ, МХЕГ, Далайн захиргаа
3	Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг шалгалтад оролцох мэргэжлийн хяналтын болон байгаль орчны байцаагчдыг мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах ажлыг зохион байгуулах	II улирал	ЗТХЯ, Далайн захиргаа, АТҮТ
Б.Хяналт шалгалтын чиглэлээр			
1	Усан замын тээврийн хэрэгслийн ээлжит техникийн хяналтын үзлэг, тооллогыг Ховд, Увс, Баян-Өлгий, Завхан, Сэлэнгэ, Булган, Төв, Хэнтий, Дорнод, Архангай, Өвөрхангай аймгуудын хэмжээнд зохион байгуулж явуулах	III улиралд	ЗТХЯ, Далайн захиргаа, АТҮТ, Орон нутгийн МХГ
2	Хөвсгөл аймгийн Ханх сум, Хатгал тосгонд усан замын тээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын тээвэрлэлтийн аюулгүй ажиллагаанд хяналт тавих, заавар, зөвлөмжөөр ханган ажиллах	III улиралд	ЗТХЯ, Далайн захиргаа
3	Усан замын тээврийн хэрэгслийн тээвэрлэлтийн болон техникийн ашиглалтын байдалд хяналт шалгалт хийх	III улиралд	ЗТХЯ, Далайнзахиргаа, МХЕГ, орон нутгийн МХГ
4	ЗТХЯ болон МХЕГ-ын 2018 оны хамтран хэрэгжүүлэх хяналт, шалгалтын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлын биелэлтийг ханган ажиллах	I - IV улиралд	ЗТХЯ, Далайнзахиргаа, МХЕГ, орон нутгийн МХГ

МОНГОЛ УЛСЫН
 ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
 Сайд Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 21 дугаар гэрээ

В. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр

1	“Усан замын тээврийн тухай” хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд холбогдох дүрэм, журмыг шинээр болон шинэчлэн боловсруулах ажлыг хэрэгжүүлэн ажиллах	I-IV улиралд	ЗТХЯ, Далайн захиргаа
2	Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх заавар, ерөнхий шаардлага” стандартын төслийг боловсруулах судалгааны ажлыг хийх	I-IV улиралд	ЗТХЯ, Далайн захиргаа

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Т.ГОМБОСҮРЭН



ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ДАРГА
С.ТУВШИНТӨР

